

## Сургуулийн сурагчдын хийжүүлсэн ундааны хэрэглээ болон нөлөөлж буй хүчин зүйлс

Болор Б.<sup>1</sup>, Жэн Чанг Лью.<sup>2</sup>, Энхмягмар Д.<sup>1</sup>

<sup>1</sup>Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн

<sup>2</sup>Азийн их сургууль

[b.bolor77@yahoo.com](mailto:b.bolor77@yahoo.com)

### Үндэслэл

Хийжүүлсэн болон чихэржүүлсэн ундааны байнгын хэрэглээ нь хүн ам ялангуяа өсвөр насны хүүхдүүдийн дундах жингийн илүүдэл, ясны сийрэгжилт, шүд цооролт, хоол тэжээлийн дутагдал зэргийн голлох шалтгаан болдог учир хөгжингүй болон хөгжиж буй орнуудын нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж байна. Хийжүүлсэн ундааны хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх судалгаа хөгжингүй орнуудад өргөнөөр хийгдсэн байдаг бол манай улсын хувьд төдийлөн хангалттай судлагдаагүй байна.

### Зорилго

Сургуулийн сурагчдын хийжүүлсэн ундааны хэрэглээ болон нөлөөлж буй хүчин зүйлийг үнэлэх

### Материал, арга зүй

Судалгааг нэг агшингийн загварыг ашиглан 2010 онд явуулсан бөгөөд ЕБС-ын 7-11-р ангийн 5238 сурагчдыг хамруулсан. Судалгааны материалд SPSS-17 программыг ашиглан статистик боловсруулалт хийлээ. Хийжүүлсэн ундааны хэрэглээг давтамжаар үнэлсэн. Олон хүчин зүйлийн ложистик регрессийн шинжилгээний аргыг ашиглан хийжүүлсэн ундааны хэрэглээнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг хүн ам зүйн, хооллох зан үйл болон сэтгэл зүйн байдлаар тодорхойлов.

### Үр дүн, хэлцэмж

Судалгаанд оролцсон сургуулийн сурагчдын 11% нь хийжүүлсэн ундааг хэрэглэдэг байна. Хүйсийн хувьд эрэгтэй сурагчдын хийжүүлсэн ундааны хэрэглээний түвшин 12,7% бол эмэгтэй сурагчдын 9,8% нь хийжүүлсэн ундааг хэрэглэж байна. Хийжүүлсэн ундааны хэрэглээний түвшин эмэгтэй сурагчдын дунд 7-р ангиас 11-р анги хүртэл 14.9%-иас 4.2% хүртэл болж буурсан байна. Эрэгтэй сурагчдын хийжүүлсэн ундааны хэрэглээний түвшин эмэгтэй сурагчидтай харьцуулахад 1.2 дахин их байна (AOR=1.22; 95% CI [1.00-1.48]).

Тус судалгаагаар 7 хоногт 3-аас дээш түргэн хоолны газраар үйлчлүүлсэн хүүхдүүдийг 3-аас бага удаа үйлчлүүлсэн хүүхдүүдтэй харьцуулахад 2.4 (AOR = 2.38, 95% CI = [1.94-2.93]) дахин их хийжүүлсэн ундааг хэрэглэж байгаа нь анхаарал татсан үр дүн байсан. Энэ нь түргэн хоолны сүлжээ газруудад хийжүүлсэн ундааны борлуулалт өндөр байдагтай холбоотой байж болно. Өглөөний цайгаа уугаагүй хүүхдүүд 1 (AOR = 1.27, 95% CI = [1.03-1.55]) дахин, хичээл тасалсан хүүхдүүд 1.5 дахин (AOR = 1.54, 95% CI [1.25-1.91]) их хийжүүлсэн ундааг хэрэглэж байна. Швед улсад хийгдсэн судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн дундах чихэржүүлсэн ундааны хэрэглээ нь амьдралын хэв маяг,

бусад хоолны сонголт, хооллолтын дадал, зуршилтай хэрхэн хамааралтай байгааг судалсан. Тус судалгааны дүнгээр өглөөний цайгаа тогтмол уудаггүй хүүхдийн дундах ундааны хэрэглээ өндөр байгааг тогтоожээ ( $P > 0.001$ ).

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн амиа хорлохыг завдах тохиолдлыг хийжүүлсэн ундааны хэрэглээтэй холбон судлахад амиа хорлохыг завдсан хүүхдүүдийн хийжүүлсэн ундааны хэрэглээ 1 дахин (AOR= 1.45, 95% CI [1.05-1.99]) өндөр байсан.

Олон улсад хийгдсэн нилээдгүй судалгаагаар чихэржүүлсэн ундааг байнга хэрэглэх нь сэтгэл гутрах, стресс, амиа хорлохыг завдах зэрэг сэтгэл зүйн асуудалтай хамааралтай байсныг судалжээ. Харин байршил болон амьдардаг орон сууцын төрөл хийжүүлсэн ундааны хэрэглээний хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй.

#### **Дүгнэлт:**

Өсвөр насны хүүхдүүдийн хийжүүлсэн ундааны хэрэглээнд эрүүл зөв хооллолтын талаарх тэдний мэдлэгхангалтгүй байгаа нь нөлөөлж байна. Хийжүүлсэн ундааны хэрэглээг бууруулахын тулд сурагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нь чухал юм.